

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН АУДИТЫН БАГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ, УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН  
БАЙГУУЛЛАГУУДЫН 2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД  
ЗАВСРЫН АУДИТ ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сайнцагаан сум

2016 оны 07 дүгээр сарын 20

- 1. Аудитын нэр:** Дундговь аймгийн орон нутгийн өмчit аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайланд хийх завсрлын аудит
- 2. Үндэслэл:** Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 203 тоот тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын 1.9 дэх заалт, Дундговь аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэв.
- 3. Зорилго, зорилт:** Санхүүгийн тайлангийн завсрлын аудитын зорилго нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын бэлтгэл ажлын хүрээнд Дундговь аймгийн орон нутгийн өмчit аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ болон холбогдох хууль, заавар журмын дагуу үнэн, зөв бэлтгэгдсэн эсэх, байгууллагын дотоод хяналтыг үнэлэх, өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, завсрлын аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг аудитын явцад арилгуулах, харилцагч байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнуудад заавар, зөвлөгөө өгөхөд чиглэгдэнэ.
- 4. Аудитаар хийгдэх ажлууд:**
  - Санхүүгийн тайлангийн аудитын журамд заасан аудитын үе шат бүрийн /аудитыг төлөвлөхийн өмнөх, төлөвлөх, гүйцэтгэх үе шатны/ ажлуудыг, гарын авлагад тусгасан маягт загварын дагуу гүйцэтгэх. Аудитын үе шатны ажлыг СТАУС програмаар гүйцэтгэнэ.
  - Хөрөнгийн үлдэгдэлд газар дээр нь биет тест хэрэгжүүлэх, үндсэн хөрөнгө, бараа материалд хэсэгчилсэн хяналтын тооллого хийх, хөрөнгийг данс бүртгэлд бүрэн, үнэн, зөв тусгасан эсэхийг тулган шалгах.
  - Санхүүжилт, орлого, зардлын гүйлгээг түүвэрлэн хууль, заавар журмын дагуу хийгдсэн эсэхийг шалгах, ажил гүйлгээг тулган баталгаажуулах, дүнгээс хөөн шалгах, давтан тооцоолол хийх;
  - Өглөг, авлагын гүйлгээг дэлгэрэнгүй журнал, ерөнхий дэвтэртэй тулган шалгах, харилцагч байгууллагаас лавлагаа авч үлдэгдлийг тулган баталгаажуулах;
  - 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан нь УСНББОУС, СТОУС, НББОУС болон холбогдох хууль, журам зааврын дагуу үнэн зөв бэлтгэгдсэн эсэхийг шалгах;
- 5. Хамрах хүрээ, арга зүй:** Завсрлын аудитад Дундговь аймгийн орон нутгийн өмчit аж ахуйн нэгкүүд, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын 2016 оны

эхний хагас жилийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл болон бусад холбогдох баримт материалыг бүрэн хамруулна.

6. **Шалгуур:** Завсрын аудит хийх зорилго, зорилтой холбогдуулан дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгоно. Үүнд:
  1. Төсвийн байгууллагуудад мөрдөх санхүү болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль, заавар журам, тогтоол, шийдвэрүүд / Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын баталсан журам, заавар, Дундговь аймгийн ИТХ-ын тогтоолууд, Засаг даргын захирамжууд ... гм /
  2. УСНББОУС, СТОУС, НББОУС
  3. Аудитын олон улсын стандарт
  4. Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын журам, гарын авлага
  5. Бусад
7. **Хугацаа:** Завсрын аудитыг 10 дугаар сарын 03-аас 12 дугаар сарын 16-ний хооронд хийж гүйцэтгэнэ.
8. **Ажлын хөтөлбөр, хуваарь:** Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөрийг Хавсралт №1, хуваарийг хавсралт №2, завсрын аудитаар гүйцэтгэх аудитын дэлгэрэнгүй горимыг хавсралт № 3-т тус тус харуулсан болно.
9. **Завсрын аудит хийх багийн бүрэлдэхүүн**

Завсрын аудитыг Дундговь аймгийн аудитын газрын аудитын менежер хянан удирдаж, Санхүүгийн аудитын багийн аудитор, шинжээч нар батлагдсан хөтөлбөрийн дагуу тус тус гүйцэтгэнэ.

Төлөвлөгөө боловсруулсан:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ГАНТУЯА